


Завхан аймгийн 2024 оны 01 дүгээр сарын гадаргын усны чанарын сарын тойм

1. Гадаргын усны чанар

Завхан аймгийн усны чанарын хяналт шинжилгээний цэгүүдэд хөтөлбөрийн дагуу Богд-Улиастай дээд, Чигэстэй-Улиастай дээд цэгүүдээс 2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр дээж авч химийн найрлага, чанарын үзүүлэлтүүдийг тодорхойллоо.

Гадаргын усны цахилгаан дамжуулах чанарын өөрчлөлтийг 2023 оны 01 сар, 2024 оны 01 сартай харьцуулж Зураг 1-т харууллаа.



Зураг 1. Гадаргын усны цахилгаан дамжуулах чанар

2024 оны 01 дүгээр сард дээхри цэгүүдэд усны цахилгаан дамжуулах чанар/ЦДЧ/ 156.9-162.6 $\mu\text{S}/\text{cm}$ байна.

Хүснэгт 1. Усны гол ионуудын агууламж

Харуул	Хатуулаг, мг-экв/л	Ca, мг/л	Mg, мг/л	K+Na, мг/л	SO ₄ , мг/л	Cl, мг/л	HCO ₃ , мг/л	Эрдэсжилт, мг/л
Богд-Улиастай/дээд/	1.36	20.0	4.4	9.5	21.0	2.5	75.1	132.5
Чигэстэй-Улиастай/дээд/	1.32	19.2	4.4	8.0	20.9	3.2	67.7	123.4
MNS4586:98					100	300		


Дээрх усны харуулын хяналт шинжилгээний цэгүүдэд ерөнхий хатуулгыг А.Е.Посоховын ангиллаар авч үзэхэд 1.32-1.36 мг-экв/л байгаа нь маш зөөлөн ангилалд орж байна.

Хүснэгт 2. Усны биогенийн нэгдлүүдийн агууламж


Харуул	pH	УХ, мг/л	БХХ ₅ , мг/л	Пич, мг/л	NH ₄ , мг/л	NO ₃ , мг/л	NO ₂ , мг/л	P, мг/л
Богд-Улиастай/дээд/	7.84	10.01	2.6	0.9	0.71	1.03	0.001	илр
Чигэстэй-Улиастай/дээд/	7.33	9.70	1.4	0.8	0.72	0.95	илр	илр
MNS4586:98		6	4.00	3.0	0.50	9.00	0.020	0.100

Тайлбар: илр-илрээгүй. УХ-Ууссан хүчилтөрөгч, БХХ₅-Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч

Биогений нэгдлүүдийн агууламжыг Монгол улсын гадаргын усны MNS4586:98 стандарттай харьцуулахад аммоны агууламж 1.4 дахин давсан байна.



Зураг 2. Усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж



Зураг 3. Усны аммоний азотын агууламж

2. Завхан аймгийн хаягдал бохир ус цэвэрлэх байгууламжийн усны хяналт шинжилгээ

2024 оны 01 дүгээр сарын 03-ний өдөр Завхан аймгийн хаягдал ус цэвэрлэх төв цэвэрлэх байгууламж/ЦБ/-ийн хаягдал бохир ус орж байгаа болон цэвэршүүлээд гаргаж байгаа цэгүүдээс нийт 2 сорьц авч хийсэн шинжилгээний дүнг MNS4943:2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн буй орчинд нийлүүлж болох хаягдал усан дахь бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ/ЗДХ/-тэй харьцуулан Хүснэгт 3-т үзүүлээ.

Хүснэгт 3. Улиастай хотын хаягдал бохир ус цэвэрлэх 1 байгууламжийн биогенийн агууламж


Хаягдал бохир ус цэвэрлэх байгууламж	Сорьц авсан цэг	pH	Ж/б, мг/л	БХХ ₅ , мг/л	Пич, мг/л	NH ₄ , мг/л	NO ₂ , мг/л	NO ₃ , мг/л	Цэвэршилт, %
Төв ЦБ	Орох	8.23	95.6	84.7	15.4	-	-	-	70.96
	Гарах	8.13	4.0	24.6	6.9	26.21	0.320	0.14	
MNS4943:2015		6-9	30.0	20.0	20.0	15.00			

Тайлбар: Ж/б-Жигнэгдэх бодис, БХХ₅-Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгч, ХХХ-Химийн хэрэгцээт хүчилтөрөгч


Шинжилгээний дүнгээс үзэхэд цэвэрлэх байгууламжаас гарч байгаа ус 70.96%-ийн цэвэршилттэй байсан бөгөөд цэвэршүүлээд гарч буй бохир усны

биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 1.2 дахин, Нийт азотын агууламж 1.8 дахин их бохирдолтой байна.

Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар, жинлэгдэх бодисын сарын өөрчлөлтийг 2023, 2024 оны 01 дүгээр сарын байдлаар зураг 4-5-т харууллаа.



Зураг 4. Төв цэвэрлэх байгууламжийн цэвэршүүлэх чадвар



Зураг 5. Төв цэвэрлэх байгууламжийн жинлэгдэх бодис

Дүгнэлт:

Гадаргын усанд 2024 оны 01 дүгээр сард хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс үзэхэд голын усны цахилгаан дамжуулах $156.9-162.6 \mu\text{S}/\text{cm}$ -т хэлбэлзэж байна.

Богд болон Чигэстэй голын ууссан хүчилтөрөгчийн горим Монгол улсын гадаргын усны стандарт MNS4586:98 дахь хүлцэх агууламжаас даваагүй.

Хаягдал бохир ус цэвэрлэх Төв цэвэрлэх байгууламжаас цэвэршүүлэгдээд гарч буй хаягдал бохир усны биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 1.2 дахин, Нийт азотын агууламж 1.8 дахин тус тус давсан байна.

Хаягдал ус цэвэршүүлэх байгууламж болох 70.96%-тайгаар цэвэршүүлсэн усыг Чигэстэй голд нийлүүлж байна.